



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/382

Булган сум

Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг
хүлээн авах байнгын ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/439 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уул уурхайн олборлолт болон дэд бүтэц, бусад үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хүлээн авах байнгын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Байгаль орчны газрын дарга
Гишүүд: Байгаль орчны газрын Байгаль орчны Хяналтын
улсын байцаагч
Байгаль орчны газрын Усны асуудал хариуцсан
мэргэжилтэн
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн
Сумын Байгаль хамгаалагч
Сумын иргэний төлөөлөл
Нарийн бичгийн дарга: Байгаль орчны газрын Газрын хэвлийн ашиглалт,
хамгаалалт хариуцсан мэргэжилтэн

2. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын холбогдох стандартын дагуу хүлээн авч ажиллахыг ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/654 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Д.ГҮРЭВ-ОЧИР



6326010515

Дугаар Ажил 2026 өдөр бүр 6326010515 Захирамж